



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 07 сарын 26 өдөр

Дугаар А/274

Улаанбаатар хот

**Баянгол дүүргийн 114 дүгээр
цэцэрлэгийн данс бүртгэлд
хөрөнгө бүртгэх тухай**


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 3 дугаар зүйлийн 3.2.3 дахь заалт, “Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2019 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2019 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу хавсралтад заасан нийт 2,949,990.0 /хоёр сая есөн зуун дөчин есөн мянга есөн зуун ерэн/ төгрөгийн үнэ бүхий эргэлтийн бус хөрөнгийг данс бүртгэлд бүртгэн авахыг Баянгол дүүргийн 114 дүгээр цэцэрлэг /М.Сарантуяа/-т зөвшөөрсүгэй.

2. Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Баянгол дүүргийн 114 дүгээр цэцэрлэг /М.Сарантуяа/-т үүрэг болгосугай.


3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн төлөөлөл, менежментийн хэлтэс /М.Энхболд/-т даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ



Ш.ҮНЭНБАТ

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын
газрын даргын 2019 оны 07...сарын
06... өдрийн А/274 дугаар тушаалын хавсралт



Бүртгэлд авах эд хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Баянгол дүүргийн 114 дүгээр цэцэрлэг

№	Эд хөрөнгийн нэр	Марк дугаар	Үзүүлэлт, хүчин чадал	Ашиглалтанд орсон	Чанар байдал	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Бүртгэлийн үнэ		Хандивлагч байгууллага	
								Нэгжийн үнэ	Нийт үнэ	Нэр	Эх үүсвэр
Машин, тоног төхөөрөмж											
1	Телевизор	Samsung	49 инч	2019	Сайн	ш	1	1,449,990.00	1,449,990.00	БНСУ-н Еадам сургууль	Хандив
Машин, тоног төхөөрөмжийн дүн									1,449,990.00		
Тавилга, эд хогшил											
2	Дрож		Орос, цэнхэр эрээн	2019	Сайн	м	20	75,000.00	1,500,000.00	Эцэг эх	Хандив
Тавилга, эд хогшлын дүн									1,500,000.00		
Нийт хөрөнгийн дүн									2,949,990.00		